

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
тайлан

Аудитын код: БӨА-2022/04/НА-СТА-ТБОНӨААН

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: М.Айнур Утас: 94159291 Цахим хаяг: ainurm@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллагын үйл ажилагаа	10
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
4. Аудитын тайлан	10
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Дотоод хяналт	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
4.4 Материаллаг байдал	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
5.1 Шилэн дансны мэдээлэл	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
8. Аудитын илрүүлэлт	15
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИНЕГ	Иргэний Нисэхийн Ерөнхий газар
ИНҮТ	Иргэний Нисэхийн Үндэсний төв

1.Аудитын санал дүгнэлт
**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ НИСЭХ
БУУДЛЫН ДАРГА К.ЕРЖАН
ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐3.15 № 318
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ
Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудлаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Баян-Өлгий аймаг дахь Нисэх буудал нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар аргачлалын дагуу бэлтгэж, санхүүгийн тайланд холбогдох мэдээллийг бүрэн толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Аудитын хамрах хүрээний хязгаарлалттай холбоотой хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	17,428,642.63	14,943,720.45
1.1.2	Дансны авлага	13,186,492.65	7,221,857.13
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	16,000.00	0
1.1.4	Бусад авлага	0	61,699.40
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	198,555,083.05	171,670,777.50
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	229,186,218.32	193,898,054.48
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,315,451,625.29	8,949,324,956.34
1.2.2	Биет бус хөрөнгө	7,287,962,058.84	7,287,555,000.49
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	23,820,700.00	41,161,546.18
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,627,234,384.13	16,278,041,503.01
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,856,420,602.45	16,471,939,557.49
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	0	20,000.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	128,874.61	0
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	500,000.00	278,000.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	628,874.61	298,000.00

2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0	0
2.1.2.1	Урт хугацаат зээл	0	0
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	0	0
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0	0
2.1.2.4	Урьдчилж орсон орлого - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	0	0
2.1.2.5	Бусад урт хугацаат өр төлбөр	0	0
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0	0
2.2	Өр төлбөрийн нийт дүн	628,874.61	298,000.00
2.3	Эздийн өмч	7,939,790,829.94	7,939,790,829.94
2.3.1	Өмч: - төрийн	7,284,500,000.00	7,284,500,000.00
2.3.2	- хувийн	0	0
2.3.3	- хувьцаат	0	0
2.3.4	Нэмж төлөгдсөн капитал	0	0
2.3.6	Халаасны хувьцаа	0	0
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0	0
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	655,290,829.94	655,290,829.94
2.3.7	Эздийн өмчийн бусад хэсэг	0	0
2.3.8	Хойшлогдсон орлого	0	0
2.3.9	Хуримтлагдсан ашиг	8,916,000,897.90	8,531,850,727.55
	Эздийн өмчийн дүн	16,855,791,727.84	16,471,641,557.49
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	16,856,420,602.45	16,471,939,557.49

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	29,136,617.78	14,028,008.96
2	Борлуулалтын өртөг	1,753,227,048.63	1,683,714,680.58
3	Нийт ашиг(алдагдал)	-1,724,090,430.85	-1,669,686,671.62
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	298,933.19	
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,550,753,112.28	1,365,821,706.55
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	420,000.00	0
11	Санхүүгийн зардал	0	0
12	Бусад зардал	85,162,868.12	80,285,205.28
13	Гадаад валютын ханшийн зөрүүнийолз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэнолз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөхашиг(алдагдал)	-258,621,253.50	-384,150,170.35
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-258,621,253.50	-384,150,170.35
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		

22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-258,621,253.50	-384,150,170.35
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютынхөрвүүлэлтийн зөрүү		
	Бусадолз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-258,621,253.50	-384,150,170.35

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	7,284,500,000.00	655,290,829.94	8,916,000,897.90	16,855,791,727.84
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
11	Залруулсан үлдэгдэл	7,284,500,000.00	655,290,829.94	8,916,000,897.90	16,855,791,727.84
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-384,150,170.35	-384,150,170.35
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт				
15	Зарласан ногдол ашиг				
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
17	2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	7,284,500,000.00	655,290,829.94	8,531,850,727.55	16,471,641,557.49

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйлажиллагааны мөнгөнгүйлгээ		

1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,175,777,418.94	1,152,675,553.85
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	18,500,000.00	1,080,990.85
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	1,156,606,019.00	1,151,594,563.00
	Бусад мөнгөн орлого	671,399.94	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,166,241,729.04	1,155,160,476.03
	Ажиллагчдад төлсөн	654,424,015.56	554,918,464.17
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	178,318,024.37	172,261,068.24
	Бараа материал худалданавахад төлсөн	99,066,129.05	244,259,361.58
	Ашиглалтын зардалд төлсөн	27,217,547.52	25,794,996.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	32,715,287.00	836,000.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	157,521,172.53	147,182,376.94
	Даатгалын төлбөрт төлсөн	6,897,900.00	6,898,000.00
	Бусад мөнгөн зарлага	10,081,653.01	3,010,209.10
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	9,535,689.90	-2,484,922.18
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	298,933.19	
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	298,933.19	
	Хүлээн авсан ногдол ашиг		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	9,834,623.09	-2,484,922.18
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,594,019.54	17,428,642.63
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,428,642.63	14,943,720.45

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

	2020 оны гүйцэтгэл	2021 оны тодотгол	2021 оны гүйцэтгэл	мянган төгрөг Хэмнэлт хэтрэлт	Хувь
ҮЗҮҮЛЭЛТ					
НИЙТ ЗАРЛАГА		1,251,806.7			
НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	1,233,876.4	1,251,806.7	1,078,184.7	173,622.1	86.1
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,141,323.9	1,241,302.6	1,052,103.6	189,199.0	84.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	714,877.9	798,956.0	663,805.5	135,150.5	83.1

Үндсэн ба нэмэгдэл цалин	614,237.9	695,006.0	565,660.5	129,345.5	81.4
Унаа хоолны хөнгөлөлт	100,640.0	103,950.0	98,145.0	5,805.0	94.4
Гэрээт ажлын цалин	-	-	-	-	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,744.8	111,853.8	93,256.5	18,597.3	83.4
Тэтгэврийн даатгал	61,456.5	71,906.0	60,720.4	11,185.6	84.4
Тэтгэмжийн даатгал	7,251.3	7,989.6	6,755.7	1,233.9	84.6
ҮОМШ-ийн даатгал	12,964.0	14,381.2	12,084.6	2,296.6	84.0
Ажилгүйдлийн даатгал	1,381.1	1,597.9	1,245.1	352.8	77.9
Эрүүл мэндийн даатгал	13,691.9	15,979.1	12,450.7	3,528.4	77.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,615.2	35,162.0	36,188.7	(1,026.7)	102.9
Гэрэл, цахилгаан	12,933.2	14,949.0	12,332.8	2,616.2	82.5
Түлш, халаалт	17,436.2	17,664.0	21,455.9	(3,791.9)	121.5
Цэвэр, бохир ус	2,245.8	2,549.0	2,400.0	149.0	94.2
Байрны түрээс	-	-	-	-	
Хангамж, бараа материалын зардал	40,698.3	47,233.8	41,143.8	6,090.0	87.1
Бичиг хэрэг	4,071.6	2,635.8	2,353.4	282.4	89.3
Тээвэр, шатахуун	27,627.8	32,544.4	29,343.7	3,200.7	90.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,082.2	4,918.0	4,085.1	832.9	83.1
Ном хэвлэл	-	-	-	-	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,357.9	5,423.0	3,705.1	1,717.9	68.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,558.8	1,712.6	1,656.5	56.1	96.7
Нормативт зардал	14,626.1	11,475.2	11,076.9	398.3	96.5
Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,626.1	11,475.2	11,076.9	398.3	96.5
Эд хогшил, урсгал засварын зардал	110,855.2	104,991.0	78,006.9	26,984.1	74.3
Багаж, техник, хэрэгсэл	80,866.1	69,026.0	42,887.6	26,138.4	62.1
Тоног төхөөрөмж	48,056.8	33,038.0	17,573.2	15,464.8	53.2
Автомашин	5,090.0	9,082.0	8,756.5	325.5	96.4
Аэродром	12,204.9	5,223.0	5,065.4	157.6	97.0
Гал унтраах зардал	15,514.4	21,683.0	11,492.6	10,190.4	53.0
Хөдөлмөр хамгааллын зардал	8,913.6	10,900.0	11,212.3	(312.3)	102.9
Урсгал засвар	21,075.5	25,065.0	23,906.9	1,158.1	95.4
Томилолт, зочны зардал	26,568.8	26,383.9	24,915.5	1,468.3	94.4
Гадаад албан томилолт	-	-	-	-	
Дотоод албан томилолт	26,568.8	26,383.9	24,915.5	1,468.3	94.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104,337.6	105,247.0	103,709.8	1,537.2	98.5

Харуул, хамгаалалтын зардал	3,445.5	3,650.0	3,117.5	532.5	85.4
Үл хөдлөх хөрөнгийн татвар	78,600.0	78,600.0	78,600.0	-	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	474.0	790.0	10.0	780.0	1.3
Даатгалын үйлчилгээ	6,897.4	6,898.0	6,898.0	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	198.0	597.0	419.8	177.2	70.3
Газрын төлбөр	14,569.0	14,568.0	14,569.0	(1.0)	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	153.7	144.0	95.5	48.5	66.3
Бараа үйлчилгээний бусад зардал	27,203.8	2,030.0	17,931.1	(15,901.1)	883.3
Бараа үйлчилгээний бусад зардал	53.4	1,030.0	690.3	339.7	67.0
Түүхий эд, материал	26,330.4	-	16,060.7	(16,060.7)	
Сургалт семинар	820.0	1,000.0	1,180.0	(180.0)	118.0
Дотоод сургалт	820.0	1,000.0	1,180.0	(180.0)	118.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,348.7	8,474.1	8,150.0	324.1	96.2
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	65,348.7	8,474.1	8,150.0	324.1	96.2
Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж	63,863.7	6,820.0	6,500.0	320.0	95.3
Эмчилгээний төлбөр	1,485.0	1,654.1	1,650.0	4.1	99.8

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудлын зорилго нь нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг найвартай хангаж, үйлчлүүлэгчдийг дээдэлсэн чанартай, соёлтой, тав тухтай үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайл эдийн засгийн үр ашигтай агаарын навигацийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, удирдан чиглүүлэх, зохион байгуулалтаар хангах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Иргэний Нисэхийн үндсэний төв, Төрийн өмчит ААТҮГ Өлгий Нисэх буудал гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудал нь 1958 оны 7 сарын 25-нд байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд авсан арга хэмжээ байхгүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу тайлант онд дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилсөн шийдвэр гараагүй, ажил үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулсан ямар нэгэн шийдвэр гараагүй боловч ИНЕГ-аас Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой ирүүлсэн албан даалгавар даалгаврын хүрээнд урсгал зардлыг хэмнэх төлөвлөгөө гарган ажиллаж, ажилчдад илүү цагийн цалин хөлсийг олгохгүй, ажилчдыг нөхөн амруулах замаар цалингийн зардлыг хэмнэж ажилласан байна. Тайлант онд ажилчдын цалинг нэмэгдүүлээгүй, цалин хөлсөнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй, баяр ёслолын үедэд ажилчдад гарын бэлэг, шагнал урамшуулал олгогдоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалтай холбоотой ямар нэгэн зардал гараагүй байна.

Иймд Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах бодлого, журамд өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Иргэний Нисэхийн аюулгүй байдлын Үндэсний хөтөлбөрт

- Нисэхийн Аюулгүй байдлын 140 дүгээр дүрэм

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудлын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17,428.6	14,943.7	2,484.9
БХХО			
Авлага	13,202.5	7,221.8	-5,980.7
Урьдчилгаа			
Бараа материал	198,555.1	171,670.8	26,884.3
Үндсэн хөрөнгө	9,315,451.6	8,949,324.9	-366,126.7
Биет бус хөрөнгө	7,287,962.1	7,287,555.0	-407.1
Хойшлогдсон татварын хөрөнгө	23,820.7	41,161.5	17,340.8
Нийт хөрөнгийн дүн	16,856,420.6	16,471,939.6	-384,481.1
Өр төлбөрийн дүн	628.8	298.0	-330.9
Богино хугацаат өглөг			
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч	7,284,500.0	7,284,500.0	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,856,420.6	16,471,939.6	-384,481.1

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 14.9 сая төгрөг болж 2.5 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь банкин дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 14.9 сая төгрөг байна.

Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд бүртгэлтэй үнэт цаас байхгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 7.3 сая төгрөг болж 5.9 сая төгрөгөөр буурсан байна. Дансны авлага 7.2 сая төгрөг, богино хугацаат бусад авлага 0.1 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 7.3 сая төгрөгийн авлага байна. Найдваргүй авлагыг нөөц байгуулаагүй, барагдах боломжтой авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 171.7 сая төгрөг болж 26.9 сая төгрөгөөр буурсан нь нөөцийн шатахууны үлдэгдлээс ИНЕГ-т 41.5 сая төгрөгийн шатахууныг татан төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 139.7 сая төгрөгийн, үнэ төлбөргүй 36.6 сая төгрөгийн материалыг хүлээн авч, нийт 176.3 сая төгрөгийн бараа материалыг бүртгэлд тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 0.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна. Энэ нь байгууллагын ашиглаж буй принтерүүдэд таарахгүй, ашиглалтгүй байгаа принтерүүдийн хор байгаа бөгөөд бараа материал дансанд үлдэгдэлд бүртгэгдэж ирсэн байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж, бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 270.2 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэснээр 15166.8 сая төгрөгөөр, шинээр 270.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсний дотор төсвийн хөрөнгөөр 19.0 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 221.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ИНҮТ-ээс хоорондын тооцоогоор авсан /худалдан авсанд бүртгэсэн/, дотоод хөдөлгөөнөөр 30.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна. Оны эцсийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл дансны үнээр 15437.0 сая төгрөг байна. Тайлант онд акталсан, балансаас баланст шилжүүлсэн хөрөнгө байхгүй байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл 7358.1 сая төгрөг ба ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй бусад байгууллага ашиглаж байгаа үндсэн хөрөнгө байхгүй байна.

Тайлант онд биет бус хөрөнгөд 0.4 сая төгрөгийн, биет хөрөнгөд 613.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна. Дотоод хөдөлгөөнөөр нэмэгдсэн үндсэн хөрөнгийн 22.9 сая төгрөгийн элэгдлийг бүртгэлд нэмж тусгасан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 0.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл бүртгэгдсэн байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудал нь жил бүрийн төсвийн төслийг өмнөх оны гүйцэтгэлийг үндэслэн боловсруулж, ИНҮТ-т 2020 оны 7 дугаар сарын 09-ны дотор хүргүүлсэн байна.

ИНҮТ-ын даргын 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 10-5/392 тоот тушаалаар Өлгий Нисэх буудлын 2021 оны үйл ажиллагааны төсвийг 1233.8 сая баталсан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогоос 90.8 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн байна.

ИНҮТ-ын даргын 2021 оны 5 сарын 05-ны өдөр Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудлын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1233.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг мөн 1233.8 сая төгрөгөөр хянаж батласан байна. Энэхүү төсөв дотор хөрөнгө оруулалтын арга хэмжээнд хөрөнгө хуваарилагдаагүй байна.

ИНҮТ-ын даргын 2021 оны 11 дүгээр сард Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудлын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1251.8 сая төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр борлуулалтын орлогоос 14.0 сая төгрөг, бусад орлогоос 1365.8 сая төгрөг нийт 1379.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 1763.9 сая төгрөгийн зардал гарган, 384.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 90.8 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 14.0 сая төгрөгийн орлого оруулж 76.8 сая төгрөг буюу 84.6 хувиар тасарсан байна. Үүнд ковид-19 цар тахлын хязгаарлалтын улмаас нислэгийн тоо буурсан нь голлон нөлөөлсөн байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас нислэгийн тоо хязгаарлагдсантай холбоотой Нисэх буудлын орлогын дүн дундажаас буурсан дүнтэй байна.

ИНУТ-ээс санхүүжилтийг нь шийдвэрлэж их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 73.3 сая төгрөгийн дээврийн их засварын ажлыг хийлгэж, ашиглалтанд хүлээн авсан байна. Энэхүү хөрөнгө оруулалтын зардлыг батлагдсан төсвийн гадуур зарцуулсан байна.

Тайлант оны зардлын нийт гүйцэтгэл /аккруель сууриар/ 1078.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 173.6 сая төгрөгөөр буюу 13.8 хувиар дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Тус төвийн үйл ажиллагаанд ИНУТ-ээс 1251.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталснаас гүйцэтгэлээр 1079.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 172.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д заасны дагуу үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад төсвийн 10 хувийг хэмнэж ажиллагаас ИНУТ-ээс 172.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, тогтоолын хэрэгжилт хангаж ажилласан байна гэж үзлээ.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 2 дүгээр сарын 15-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудлын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудлын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ИНЕГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудитын газар нь Нисэх буудлын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд бүрэн, 2021 оны эхний 4 сарын санхүүгийн үйл ажиллагаанд онлайн шалгалт хийсэн байна.

Аудитын дүнгээр ээлжийн амралтаа бүрэн эдлээгүй 1-4 хоногийн өмнө ажилдаа эргэн орсон 7 ажилтны ажилласан хугацаанд нь цалин бодож олгосноос ээлжийн амралт, цалин давхацсан, зайнаас ажилласан ажилтнуудад үр дүнгийн нэмэгдлийг журамд заасан хувиар бодож олгоогүй, ээлжийн галч нарын цалинг бодохдоо ажлын цагийг нэгтгэн бодох журмыг хэрэгжүүлж, төсвийг хэмнэж ажиллаагүй, Шилэн дансны тухай хуульд заасан хугацаа, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийлэг стандартыг тогтоох тухай журмыг зарим заалтыг хэрэгжүүлээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасныг зөрчиж 19.0 сая төгрөгийн нүүрсийг шууд худалдан авсан зэрэг зөрчилд 8 зөвлөмж өгснийг биелүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны 12 сарын 31-ны нийт зардал 1838.8 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 36.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 27.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баян-Өлгий аймаг дахь Өлгий Нисэх буудал нь тайлант онд нийт 1152.6 мянган төгрөгийн 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас, 145 мэдээллийг хугацаанд байршуулж 7.1 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өлгий Нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй болно.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно. Аудитын дүнгээр Зөрчилгүй санал дүгнэлт өгөв.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой залруулга хийгдээгүй болно.

8.2 Төлбөрийн акт

Байхгүй

8.3 Албан шаардлага

Байхгүй

8.4 Зөвлөмж

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
							Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
	Аймаг дахь Өлгий Нисэх буудал	БӨА-2022/04/НА-СТА-ТБОНӨААН			-	-										
ДҮН																
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
	Аймаг дахь Өлгий Нисэх буудал	БӨА-2022/04/НА-СТА-ТБОНӨААН			-	-										
ДҮН																
НИЙТ ДҮН																